

Жендэрийн үндэсний хорооны ажлын албанд “Дархан бэр өргөмжлөх” түүнтэй төстэй агуулга, нөлөөлөл бүхий үйл ажиллагааг зарим төрийн болон төрийн бус байгууллага хамтран зохион байгуулж байгаа талаар иргэдээс гомдол мэдээлэл ирж байгаатай холбогдуулан бүх шатны төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд тус арга хэмжээг зохион байгуулахыг хориглохтой холбоотой “Жендэрийн үндэсний шинжээчийн бүлгийн дүгнэлт”-ийг танилцуулж байна.

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ШИНЖЭЭЧИЙН БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр

“Дархан бэр” арга хэмжээ Монгол Улсын
хууль зөрчиж байгаа тухай

Жендэрийн үндэсний шинжээчдийн бүлгийн зүгээс: Төрийн болон төрийн бус зарим байгууллагаас зохион байгуулж байгаа “Дархан бэр” өргөмжлөх, түүнтэй төстэй бусад арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг зөрчиж байгаа талаар дараах дүгнэлтийг гаргав.

НЭГ. ХУУЛИЙН ҮНДЭСЛЭЛ ШААРДЛАГА

1.1. Монгол Улсын Үндсэн хуульд:

Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, **хууль дээдлэх** нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”

Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт: “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, **ХҮИС**, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь **ялгаварлан гадуурхаж үл болно**”,

Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11-т: “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд **эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй**.”

Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Үндсэн хуульд хууль, зөрлиг, **төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино**.” гэж тус тус заасан.

1.2. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд:

4.1.3. “жендэрийн хэвшмэл үзэл” гэж улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд **эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр** уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлагыг;

4.1.4. “жендэрийн ялгаварлан гадуурхалт” гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд болон аливаа бусад салбарт **эрэгтэй, эмэгтэй хүнийг хүйсийн шинж, гэрлэлтийн байдлаар ялгаварлах, үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүйг;**

4.1.5. "Жендэрийн шууд ялгаварлан гадуурхалт" гэж бусдыг хүйсээр ялгаварлаж адил буюу ижил төстэй нөхцөлд эсрэг хүйсийн хүнээс ялгаатай байдалд хүргэсэн, эсхүл хүргэхийг оролдсон үйлдлийг;

6.1. "Улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд жендэрийн ялгаварлан гадуурхалтыг хориглоно" хэмээн тус тус заасан.

ХОЁР. "ДАРХАН БЭР" АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ ЗАРИМ МЭДЭЭЛЭЛ:

Баянгол дүүргийн гэр бүл ёслолын ордон нь 3 ба түүнээс дээш хүү төрүүлсэн ээжүүдийг "Дархан бэр"-ээр алдаршуулах ёслол хийж байсан.

Монголын гэр бүлийн академи Дархан бэр медаль гаргасан. <http://time.mn/n/m9o>

Түүнчлэн интернетээр хайлт хийхэд Дархан бэр хэмээх фэйсбүүк хуудас, Дархан бэрийн тухай дуу, Дархан бэр өргөмжлөл, энэ нь 68000 төгрөг болон 500000 хүртэл төгрөгийн үнэтэй, Дархан бэр өргөмжлөлийг төрөөс олгуулахаар хооцолдож байгаа гэх зэргээр олон төрлийн мэдээлэл оруулсан байна.

Энэ асуудал сүүлийн үед ихээхэн түгээмэл болж, "Уран бэр" өргөмжлөх зэргээр өргөжин хүрээгээ тэлж, олон нийтийн зүгээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр санал бодлоо илэрхийлсэн, шүүмжлэлтэй хандсан зүйлс ч нэлээд байна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

3.1. Дээр дурдсан болон дурдаагүй төрийн ба төрийн бус байгууллагаас явуулж байгаа Дархан бэр өргөмжлөх зэрэг түүнтэй төстэй арга хэмжээ нь үр хүүхдүүдээ хүйсээр нь ялгаварлахын зэрэгцээ эмэгтэйчүүдийг ямар хүйсийн хүүхэд төрүүлснээс нь хамааруулан ялгаварлан гадуурхсан агуулга бүхий байх тул энэ Дүгнэлтийн Нэг дэх хэсэгт үндэслэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн заалтууд болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн заалтуудыг тус тус зөрчиж байна.

3.2. Энэ дүгнэлтийг холбогдох төрийн ба төрийн бус байгууллагад хүргүүлэн хууль зөрчсөн үйлдлээ таслан зогсоож, хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ тухайгаа мэдээлэхийг үүрэг болгуулахаар Жендэрийн үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Т.Энхбаярт хүргүүлэв.

3.3. Аймаг, сум, дүүрэгт зохион байгуулагдаж байгаа "Дархан бэр", "Уран бэр" өргөмжлөх зэрэг хүйсэд суурилсан алагчлалын агуулга, нөлөөлөл бүхий санаачилга, арга хэмжээг төрийн бүх шатны байгууллага зохион байгуулах, биечлэн болон төлөөлөн оролцох, төсвийн санхүүжилтийг бүрэн болон хэсэгчлэн зэргээр аливаа байдлаар санаачлах, хамтрах, дэмжихээс татгалзах, энэ хүрээнд холбогдох хяналтыг тавьж ажиллах, түүнчлэн нийт байгууллага, иргэдийн зүгээс ийм төрлийн арга хэмжээ

зохион байгуулахыг таслан зогсооход чиглэсэн үйл ажиллагаа явуулахыг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт зөвлөв.

3.4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16.1.4-т зааснаар "жендэрийн эрх тэгш байдлыг эрхэмлэсэн соёлыг төлөвшүүлэх гэгээрэл, сурталчилгааны ажлыг хүн амын дунд зохион байгуулах, **хүнийг ялгаварлан гадуурхахад чиглэсэн мэдээлэл, ухуулга, сурталчилгаанаас олон нийтийг хамгаалах арга хэмжээ авах**", 16.1.5-д заасан **"төрийн байгууллагын үйл ажиллагаа, ажлын байрыг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах зорилгод нийцүүлэн төрийн албаны стандарт батлан хэрэгжүүлэх"** талаар Засгийн газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх, нийгэм дэх жендэрийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагаа, оролцоог хангаж ажиллахыг зөвлөмж болгож байна.

ДҮГНЭЛТ ГАРГАСАН:

ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ШИНЖЭЭЧДИЙН БҮЛЭГ